**Бага боловсролын “Хүн ба байгаль”-ийн бие даан суралцах ажлын дэвтрийн хариултын хуудас**

Бүлэг сэдэв: **Амьд бие амьдралын орчин**

Дэд сэдэв: **Амьд биеийн үндсэн шинж**

Анги: **4 дүгээр анги**

| | | |
|---|---|---|
| 1.<br>Ойлгох түвшин | 1 Надад болон миний хайртай гөлгөнд амьд явахад **зайлшгүй** шаардлагатай **амин чухал** зүйлсийг холбон зураарай.<br><br> | |
| 2.<br>Хэрэглэх түвшин | 2 Дээрх даалгавраас амьд биесийн ерөнхий шинж юу болохыг эргэцүүлэн бодоод дараах өгүүлбэрийн утгад тохирох үгсийг зөв сонгон бичээрэй.<br>Сонгох үгс: том болох, хөдлөх, амьсгалах, хооллох, үржих, ялгаруулах<br>Бухий л амьд биес агаараар ..**амьсгалах**........., усаар ундаалж ,шимт бодисоор ..**хооллох**.., өсөж ..**том болох**, үр удмаа үлдээн олон болон ..**үржих**....., идэш тэжээлээ олж идэх ба биеэ хамгаалахын тулд тулд ......**хөдлөх**...., биед хэрэггүй зүйлийг ..**ялгаруулах** зэрэг шинжүүдтэй байдаг. Амь бие бүр өөрийн онцлогт тохирсон амьдрах орчинтой байдаг. | . |
| 3.<br>Задлан шинжлэх түвшин | 3 Ургамал ба амьтанд амьдрах болон өсөх хөгжихөд нь хэрэгтэй зүйлсийг Эйлерь Веннийн диаграммд байрлуулаарай.<br><br> | |

Бүлэг сэдэв: **Амьд бие амьдралын орчин**

Дэд сэдэв: **Ургамал орчиндоо зохицох нь**

Анги: **4 дүгээр анги**

<table>
<tr>
<td>1.<br>Ойлгох түвшин</td>
<td>

**Даалгавар**

1 Ургамал ургахад хэрэгтэй зүйлсээ ямар эрхтнээрээ дамжуулан амьдрах орчноосоо хүлээн авдаг вэ? Эргэцүүлэн бодоод холбон зураарай.




</td>
<td></td>
</tr>
<tr>
<td>2.<br>Хэрэглэх түвшин</td>
<td>

2 Ургамлын эрхтэн нь ямар газар нутагт оршин байгаагаас шалтгаалан өөр байж болох уу? Энэ асуултанд хариулахыг тулд манай орны байгалийн бүсүүдийн онцлогийг санацгаая. Зөв утгатай тохируулан холбоорой.




</td>
<td>.</td>
</tr>
<tr>
<td>3.<br>Задлан шинжлэх түвшин</td>
<td>

3 Дараах ургамлууд **говь цөл, хээр тал, ой тайга** зэрэг байгалийн аль бүсэд ургадаг болохыг нэрлээд учрыг тайлбарлан бичээрэй.




Гоёо нь говь цөлд ургадаг эмийн ургамал бөгөөд навч нахиагүй, иш бүдүүн зөөлөн байдаг нь ус нөөцлөхөд зохицсон байдаг.<br>
Таана нь хээр тал ургадаг сонгины төрлийн ургамал бөгөөд навч нь том биш нарийн байдаг нь хээр тал газар нарны тусгал их байдагт зохицсон байдаг.<br>
Халиар нь ойн орчим ургадаг сонгины төрлийн ургамал бөгөөд ойд нарны тусгал бага тусдаг тул нарны гэрлийг хангалттай хүртэхийн тулд зохицсон том навчтай байдаг.<br>
/ Хүүхдүүд дээрх тайлбарыг утгыг ерөнхийд нь ойлгож товч үгээр хариулсан байхад болно. Хамгийн гол нь улаанаар тодруулсан утга хэр илэрч байна вэ? гэдэг нь чухал.

</td>
<td></td>
</tr>
</table>

Бүлэг сэдэв: **Амьд бие амьдралын орчин**

Дэд сэдэв: **Амьтад орчиндоо зохицох нь**

Анги: **4 дүгээр анги**

1.
Ойлгох түвшин

1 Дараах амьтдын нэрийг нь бичээд амьдралын орчинтой нь зөв холбоорой.




2.
Хэрэглэх түвшин

2 Эдгээр амьтад амьдрах орчиндоо зохилдсон биеийн бүтцийн болон зан авирын ямар зохилдолгоо байна вэ? Сайтар эргэцүүлэн бодоод хүснэгтийг нөхөөрэй.

| Амьтны шинж | Юунд зохицсон болох | Биеийн бүтцийн зохилдолгоо | Зан авирын зохилдолгоо |
|---|---|---|---|
| Тэмээний тавхай өргөн том байдаг. | элсэнд шигдэхгүй явах | √ | |
| Тэмээ хоёр бөхтэй байдаг. | их хэмжээний ус нөөцлөхөд | √ | |
| Анаашны хүзүү нь урт байдаг. | хоол тэжээлээ олж идэх | √ | |
| Тоншуулын хошуу нь хурц , үзүүртэй | хоол тэжээлээ олж идэхэд | √ | |
| Азарга үргэлж адуун сүргийнхээ урд явдаг. | сүргээ хамгаалахад | | √ |
| Гүрвэлийн өнгө нь хувирдаг. | биеэ хамгаалахад | √ | |
| Сармагчингийн сүүл урт байдаг. | модонд дүүлж хоолоо олоход | √ | |
| Оцон шувуунууд их хүйтэнд тэврэлддэг. | дулаанаа хадгалахад | | √ |
| Тарвага хошхирдог. | аюул ирэхэд бусдадаа дохио өгөх | | √ |

.

Бүлэг сэдэв: **Амьд бие амьдралын орчин**

Дэд сэдэв: **Идэш тэжээлийн хэлхээ**

Анги: **4 дүгээр анги**

**1. Ойлгох түвшин**

1 Манай орон нутагт амьдардаг бидний сайн мэдэх эдгээр амьтад идэш тэжээлээ хэрхэн олж иддэгийг санаарай.
Амьтдыг ямар идэштэн болохыг тодорхойлоод √ тэмдгээр тэмдэглээрэй.
Эдгээр амьтдаас нэг нь нөгнийхөө идэш болон идэш тэжээлийн холбоо үүсгэдэг амьтад байна уу? / Жишээг хараарай /

| Амьтны нэр | Өвсөн идэшт | Махан идэшт | Элдэв идэшт |
|---|---|---|---|
| чоно | | √ | |
| Хонь | √ | | |
| баавгай | | | √ |
| туулай | √ | | |
| Үнэг | | √ | |
| зэрлэг гахай | | | √ |

Чоно → хонь
Үнэг → туулай
Чоно → туулай
гэх мэт

**2. Ойлгох түвшин**

2 Дээрх даалгавраас харахад ихэнх махан идэштний хоол тэжээл нь голдуу өвсөн идэштэн байна. Дараах өгүүлбэрийн дутуу орхисон үгийг нөхөж бичээрэй.

**Нэг орчинд амьдардаг амьд биес хоорондоо идэш тэжээлээрээ холбоотой байдаг. Үүнийг ..Идэш тэжээлийн хэлхээ.. гэж нэрлэнэ. Идэш тэжээлийн хэлхээ бүр ногоон ургамлаар эхлэнэ.**

.

**3. Задлан шинжлэх түвшин**

3 Өгөгдсөн амьд биесийг идэш тэжээлийн холбоогоор нь зөв байрлуулсан эсэхийг ажиглаарай. Хэрэв буруу гэж үзвэл идэш тэжээлийн хэлхээг зөв дараалалд оруулж бичээрэй. ***ногоон ургамал, мэлхий, тогоруу, эрвээхэйн авгалдай, хэдгэнэ, бүргэд***



*Ногоон ургамал* → Эрвээхийн авгалдай → хэдгэнэ → мэлхий → тогоруу → бүргэд

Бүлэг сэдэв: **Амьд бие амьдралын орчин**

Дэд сэдэв: **Хүн байгалийн шүтэн барилдлага**

Анги: **4 дүгээр анги**

| | | |
|---|---|---|
| 1.<br>Задлан шинжлэх түвшин | 1 Хүн байгальд ямар сөрөг нөлөө үзүүлдэг бол дээрх QR кодыг уншуулан, дүр<br>бичлэгийг үзэж, бичлэг дээрх хүний сөрөг үйл ажиллагааг жагсаан бичээрэй.<br><br>Бичлэгнээс дараах сөрөг нөлөөнүүдийг олж харна.<br>Ойг их хэмжээгээр устгах, ахуйн болон үйлдвэрийн хог хаягдлыг гол мөрөн, байгальд хаях, ан амьтдыг үйл олноор нь агнах, тэдний амьдрах орчинг устгах гэх мэтээр тоочин бичнэ. | |
| 2.<br>Задлан шинжлэх түвшин | 2 Хүмүүсийн хийдэг эдгээр буруу үйл ажиллагаанаас болж ургамал, ан амь<br>нөлөөлж болон нөлөөллөөс тус бүр 4-ийг тоочин бичээрэй.<br><br>  <br><br>Гол мөрний ус татрах, үүнээс шалтгаалж ургамал ургах нь ховор болох, ан амьтны идэш тэжээл ховордох, хоргодох орон гэргүй болох үүнээс шалтгаалж үхэж үрэгдэх гэх мэт..<br><br>Гол ус руу үйлдвэрийн хог хаягдал хийснээр хүн амьтны уух ус хордох, элдэв өвчин тусах, үхэж үрэгдэх,ургамал ногоо устаж ургахаа болих, ургамлаар хооллож байгаа<br><br>Байгальд хог хаягдал их хаяснаар байгаль бохирдох, орчин тойрны ус гол мөрөн бохирдох, цаашлаад ургамал амьтан хордох өвчлөх<br><br>Хүмүүсийн буруутай эдгээр үйлдлүүдээс үүсэх сөрөг нөлөө ерөнхийдөө амьд байгальд сөргөөр нөлөөлж үүнээс үүдэн өнөөдөр дэлхийн дулаарал эрчимтэй явагдаж, байгалийн гамшигт үзэгдлүүд ихсэх болсон гэдгийг нийтэд нь дүгнэн бичиж болно. | . |
| 3.<br>Бүтээх түвшин | 3 Танай орон нутагт хүмүүсийн буруутай үйл ажиллагаанаас болж хово<br>байгаа ургамал, амьтан байгаа юу? Эдгээр амьд биеийг хамгаалахь<br>юу хийвэл зохих вэ? Аав , ээж , ах эгчтэйгээ хамтран ярилцаад бичэ<br><br>Өөрийн орон нутагт буюу монгол улсын хэмжээнд ховордож байгаа амьтан ба ургамал юу байгааг судлах ба үүнийг зогсоохын тул өөрийн болон гэр бүл, найз нөхдийн зүгээс ямар алхам хийж болохыг хамтдаа ярилцаны дараа өөрийн бодлыг илэрхийлэн бичнэ. Хүүхэд бүрийн оршин амьдарч байгаа газар нутгийн онцлогоос шалтгаалан илэрхийлж байгаа санаа нь өөр өөр байна. | |